

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2009 оны 11 дүгээр сарын 19 ний өдрийн 261  
дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

## **МАЛЫН ЭМИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Малын эмийн салбар зөвлөл (“цаашид “Эмийн зөвлөл” гэх )- ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Эмийн зөвлөл нь үйл ажиллагаандаа “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”, “Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 1.3 Эмийн зөвлөл нь мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэх эмийн чанар, аюулгүй байдлын шаардлагын түвшинд байлгах, нэр төрлийг олшруулж, сонголт хийх бололцоог өргөтгөх зорилгоор эм, эмийн түүхий эдийн стандарт боловсруулахад дүгнэлт гаргах, шинэ эмийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулах, зах зээлд хэрэглэж байгаа эмийн зүйлд тандалт хийж, үнэлэмж өгөх үүрэг бүхий орон тооны бус, мэргэжлийн зөвлөх байгууллага мөн.

### **Хоёр. Удирдлага зохион байгуулалт**

- 2.1 Эмийн зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд Малын эмийн зөвлөлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох газар, хэлтсийн дарга тэргүүлнэ.
- 2.2 Малын эмийн салбар зөвлөл нь холбогдох төрийн захиргааны болон хяналтын асуудал эрхэлсэн байгууллага, сургалт, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл оролцсон 9 –өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байж болно.
- 2.3 Эмийн зөвлөлийн ажлын албаны үүргийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.
- 2.4 Эмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байна. Хуралдааныг зөвлөлийн дарга, түүний эзгүйд гишүүдийн олонхийн саналаар томилогдсон гишүүн удирдана.
- 2.5 Эмийн зөвлөл улиралд нэг удаа хуралдана. Шаардлагатай үед ээлжит бус хуралдааныг зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно. Зөвлөлийн гишүүдийн ирц 80– аас дээш хувьтай бол хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 2.6 Эмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэж зөвлөмж, дүгнэлт гаргана.
- 2.7 Эмийн зөвлөл нь стандартын дагуу хийсэн “Малын эмийн салбар зөвлөл” гэсэн албан хэргийн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 2.8 Эмийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Гурав. Малын эмийн зөвлөлийн үүрэг, эрх**

- 3.1. Эмийн зөвлөл нь дараах үүрэг хүлээнэ Үүнд:
  - 3.1.1 эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд дүгнэлт өгөх, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар Эмийн үндэсний зөвлөлд санал, танилцуулга, зөвлөмж бэлтгэж өгөх;
  - 3.1.2 мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэх эм, эмийн түүхий эдийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох баримт бичиг, эрх бүхий лабораторийн дүнг үндэслэн хэлэлцэж шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийн биелэлт, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих;
  - 3.1.3 мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэж буй эм, эмийн түүхий эдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эмийн мэдээлэл, зар сурталчилгааны асуудлаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах, энэ талаар нийтэд мэдээлэх;а

- 3.1.4 мал эмнэлгийн Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн батлуулах, хэрэглээнд шаардагдах эмийн нэр төрлийг олшруулах, эмчилгээ, оношлогоонд олон улсын жишигт нийцсэн эм хэрэглэх асуудлаар зөвлөмж гаргах;
- 3.1.5 Мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэж буй эмийн лавлах, Үндэсний фармакопейн талаар санал дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх;
- 3.1.6 эмийн стандартын төсөлд санал өгөх;
- 3.1.7 Эмийн үйлдвэрлэлийн нөхцөлд үнэлэмж өгөх;
- 3.1.8 мал, амьтны биед дасах болон гаж нөлөө ихтэй эмийг хориглох, хязгаарлах асуудлаар зөвлөмж дүгнэлт гаргах;
- 3.1.9 мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэхээр бүртгэгдсэн эмийн чанар, аюулгүй байдал, хүн, мал, амьтны биед үзүүлж байгаа нөлөөллийн талаар гарсан санал, гомдлын дагуу тухайн эм, бэлдмэлийг шалгалт туршилтад хамруулах, гарсан дүнг хэлэлцэж баталгаажуулах, нийтэд мэдээлэх;
- 3.1.10 эрх хэмжээний асуудлаар олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах, улс, орон нутгийн чанартай хурал цуглаанд оролцох, зохион байгуулах
- 3.2. Малын эмийн зөвлөл нь дор дурдсан эрх эдлэнэ.
  - 3.2.1 эмийн технологийн талаарх баримт бичгийг холбогдох байгууллага, зохиогчоос гаргуулан авах;
  - 3.2.2 эм, эмийн түүхий эд болон бичиг баримтыг магадлан шинжлэх ажилд эмийн чиглэлээр мэргэшсэн шинжээчийг үндсэн байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах;
  - 3.2.3 мал эмнэлгийн практикт хэрэглэх явцад тухайн эмийн эмчилгээний идэвх, чанар, аюулгүй байдалтай холбогдсон нотолгоотой гомдол, санал гараагүй эмийн сорилт туршилтын дүнг харгалзан улсын бүртгэлийн хугацааг зөвлөлийн хуралдаанд оруулахгүйгээр шууд сунгах;
  - 3.2.4 малын эмийн улсын бүртгэлийн дүрэмд заасан баримт бичгийн бүрдүүлэлт нь шаардлага хангаагүй гэж үзвэл уг асуудлыг Эмийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхгүйгээр бүртгүүлэгчид буцаах;
  - 3.2.5 аливаа байгууллагаас эмийн талаар гаргасан шийдвэр нь холбогдох хууль, тогтоомжид нийцэхгүй байна гэж үзвэл хүчингүй болгох саналаа зохих байгууллагад тавих;
  - 3.2.6 малын эмийн зөвлөлийн гишүүд хуралдаан, зөвлөлөөс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцсон тохиолдлод холбогдох хууль эрх зүйн хүрээнд урамшуулал авах эрхтэй
  - 3.2.7 Эмийн хэрэглэх зааврыг зөвлөлийн хуралдааны санал, зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн Монгол улсын малын ерөнхий эмч батлан мөрдүүлнэ.

#### **Дөрөв. Зөвлөлийн даргын ажил үүргийн чиглэл**

- 4.1 Эмийн зөвлөлийн дарга нь зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон хуралдаанаас гарсан шийдвэрийг баталж, шаардлагатай гэж үзвэл зарим асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлнэ.
- 4.2 Эмийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тухайн жилийн төсвийн багцад тусгуулна.
- 4.3 Эмийн зөвлөлийн дарга зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж хуралдааныг удирдана.
- 4.4 Нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавина.
- 4.5 Зөвлөлийн хагас, бүтэн жилийн ажлын тайланг гаргаж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлд танилцуулна.

#### **Тав. Эмийн зөвлөлийн нарийн бичгийн даргын ажил үүргийн чиглэл**

- 5.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Эмийн зөвлөлийн даргатай зөвшилцөн боловсруулж батлуулан хуралдааны бэлтгэл ажлыг хангана.
- 5.2. “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах, зохион байгуулан тайлагнана.

- 5.3. Эмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх эм, эмийн түүхий эдийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан албан ёсоор ирүүлсэн баримт бичигт хянан шүүлт хийж шаардлага хангасан гэж үзвэл хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараана.
- 5.4. Хуралдааны тэмдэглэл хөтөлж, гарсан шийдвэрийг баталгаажуулж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.5. Эмийн улсын бүртгэлийг хариуцан бүртгэл мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 5.6. Шинээр бүртгэсэн эм, бүртгэлээс хасагдсан эмийн талаар хагас жил тутамд, нийтэд мэдээлнэ
- 5.7. Эмийн зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг хариуцан ажлын тайланг хагас бүтэн жилээр гаргаж хуралдаанд танилцуулна.
- 5.8. Эмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой албан хэргийг хөтөлж, баримт бичгийг яамны архивт хүлээлгэн өгнө.

### **Зургаа. Хариуцлага хяналт**

- 6.1 Эмийн зөвлөл нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын өмнө үүрэг хариуцлага хүлээнэ
- 6.2 Зөвлөлийн үйл ажиллагаанд нь Төрийн нарийн бичгийн дарга хяналт тавина

-----oOo-----

## МАЛЫН ЭМИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор мал эмнэлгийн практикт хэрэглэх эх орны үйлдвэрийн болон импортын эм, биобэлдмэлд сорилт туршилт хийсний үндсэн дээр “Малын эмийн улсын бүртгэл”- д бүртгэх, бүртгэлээс хасах харилцаанд энэ дүрмийг баримтална.
- 1.2 Малын эмийн улсын бүртгэл, эмийн чанарын баталгаа, мэдээлэл, сурталчилгааны асуудлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Малын эмийн салбар зөвлөл (цаашид “Эмийн зөвлөл” гэх) –ийн хуралдааны зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлнэ.
- 1.3 Эмийн бүртгэлийн холбогдох материалыг хүлээн авах, Эмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 1.4 Эм бүртгүүлэх өргөдөл, холбогдох бичиг баримтыг зөвхөн монгол хэл дээр бүрдүүлнэ.
- 1.5 Итгэмжлэгдсэн лаборатори малын эмэнд албан ёсны сорилт туршилт хийж, дүгнэлт гаргана.
- 1.6 Малын эм, эмийн түүхий эдийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгосны дараа үйлдвэрлэх, импортлох, худалдах, эмчилгээний практикт хэрэглэх, гэрээ хэлэлцээрт тусгахыг зөвшөөрнө.
- 1.7 Малын эмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан малын эм хэрэглэх зааврыг Монгол Улсын малын ерөнхий эмчээр батлуулан мөрдөнө

### Хоёр. Эм бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлага

- 2.1 Дор дурдсан эм бэлдмэлийг эмийн бүртгэлд бүртгэнэ:
  - 2.1.1. мал эмнэлгийн эмчилгээний практикт хэрэглэгдэж байсан боловч эмийн тун, савлалт, эмийн хэлбэр, эмчилгээний идэвхи, найрлага, хэрэглэх заалт болон үйлдвэрлэлийн технологит өөрчлөлт орсон;
  - 2.1.2. эх орны болон гадаадын эмийн түүхий эдээр үйлдвэрлэсэн шинэ эм, нийлмэл найрлагатай эмийн хэлбэр, гадаадын байгууллага, судлаачтай хамтран бүтээсэн шинэ эм, амьтан, ургамлын гаралтай эм;
  - 2.1.3. эмийн үйлдвэрлэлд шаардлагатай импортын түүхий эд, туслах бодис;
  - 2.1.4. олон улсын зээл, тусламжаар импортлох эм, эмийн түүхий эд,;
  - 2.1.5. гарал үүслийн улсад эм, эмийн зүйл хэмээн бүртгэсэн, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн эмчилгээний тун бүхий амин дэм, эмэн эмчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх зориулалтын эмийн зүйл;
  - 2.1.6. ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, бодис
  - 2.1.7. Эмийн түүхий эд
- 2.2. Дор дурдсан эм бэлдмэл бүртгэлд хамаарахгүй:
  - 2.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар бүгино хугацаанд хэрэглэхийг зөвшөөрсөн эм бэлдмэл, өнчин эм, хандив тусламжийн эм, эм, эмнэл зүйн судалгаа шинжилгээ, туршилтын ажилд шаардагдах эмийн дээж
  - 2.2.2. оношлуурын зүйл;
  - 2.2.3. цацраг идэвхт бодисууд, тэдгээрийн бэлдмэлүүд;
  - 2.2.4. химийн урвалж болон бүх төрлийн тэжээлт орчин;
  - 2.2.5. лабораторийн зориулалтаар хэрэглэгдэх будаг;
  - 2.2.6. фармакопейн дагуу бэлтгэсэн, хадгалах хугацаа богино, хязгаарлагдмал хүрээнд хэрэглэхээр улс, аймаг, нийслэлийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудад бэлтгэдэг шингэн, түрхлэг;

- 2.2.7. олон найрлагатай амин дэмийн бэлдмэл;
  - 2.2.8. биологийн идэвхитэй бодис агуулсан ургамал, амьтан, эрдсийн найрлагатай бүтээгдэхүүн;
- 2.3 Эх орны үйлдвэрийн эм бэлдмэлийг бүртгүүлэхэд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:
- 2.3.1 эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, эмийн түүхий эдийн бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, үйлдвэрийн танилцуулга
  - 2.3.2 тухайн бүтээгдэхүүний батлагдсан Монгол улсын стандарт (MNS ... )
  - 2.3.3 тухайн эмийн сорилт туршилтын тайланг хэлэлцсэн мал эмнэлэгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн салбарын эрдмийн зөвлөлийн хуралдааны албан ёсны тэмдэглэл
  - 2.3.4 тухайн эм, биобэлдмэлд сорилт, туршилт хийсэн малын эм шалгах болон шаардлагатай үед бусад эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, баталгаажуулалтын дүн;
  - 2.3.5 бүтээгдэхүүний тогтвортой байдал, гаж нөлөө, эмийн харилцан нөлөөлөл, хорон чанар, идэвхи, аюулгүй байдлыг судалсан дүн, сорилт, туршилт хийсэн судалгааны дэлгэрэнгүй материал, дүн;
  - 2.3.2 эмийн хэрэглэх зааврын төсөл;
- 2.4 Импортын эм бүртгүүлэх хуулийн этгээд дараах баримт бичгийг баталгаажуулсан монгол орчуулгын хамт эмийн зөвлөлийн нэр дээр ирүүлнэ. Ирүүлсэн аливаа материалыг эзэнд нь буцаан олгохгүй.
- 2.4.1 энэ дүрмийн 7 дугаар хэсэгт заасан улсын бүртгэлд эм бүртгүүлэх өргөдлийн дагуу гаргасан баримт бичиг; (монгол, англи эсхүл орос хэл дээр )
  - 2.4.2 тухайн эмийн үйлдвэрийн танилцуулга, үйлдвэр нь олон улсын стандарт, чанарын шаардлага (GMP эсхүл ISO) хангасныг нотлох баримт бичиг;
  - 2.4.3 тухайн эмийг үйлдвэрлэгч орны болон өөрийн орны эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторийн сорилт баталгаажуулалтын дүн;
  - 2.4.4 эмзүй, эмнэлзүйн туршилтын нийтлэгдсэн материал, / гол үйлчлэгч, туслах бодис, тогтвортой чанарын шинжилгээ судалгааны дүн, эмийн хорон чанар, идэвхи, найрлага, аюулгүй байдал, харилцан нөлөөллийг судалсан дүн/ шалгах арга, аргачлал/
  - 2.4.5 тухайн эмийн найрлага, химийн шинж чанар, хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, эмийн харилцан үйлчлэл, тун хадгалах нөхцөл, сэрэмжлүүлэг зэргийг тусгасан баталгаажсан загварын дагуу бичигдсэн хэрэглэх заавар,
  - 2.4.6 эмийн зөвлөлөөс тогтоосон хэмжээний сорилт туршилтад шаардагдах хэмжээний эмийн дээж;
  - 2.4.7 эмийн гарал үүслийн гэрчилгээ /Бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан, үйлдвэрийн бүртгэлийн болон чөлөөт худалдаа, шинжилгээний сертификат г.м/
- Жич: Эмийн түүхий эдийг улсын бүртгэлд бүртгэхэд үйлдвэрлэгчийн GMP гэрчилгээ, бүтээгдэхүүний сертификат, шинжилгээний дүн, аргачлал, Гаалийн болон эмийн шинжилгээний лабораторийн сорилтын дүн, БОЯ-ны орчны үнэлгээний дүгнэлт, холбогдох бусад материалууд орчуулгын хамт
- 2.5 Мал эмнэлгийн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд батална.
- 2.6 Эмийн бүртгэлд бүтээгдэхүүнээ бүртгүүлэхийг хүсэгч үйлдвэрлэгч шууд эсхүл үйлдвэрлэгчийг албан ёсоор манай улсад төлөөлөх хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулсан эх, бичиг баримт, материалыг малын эмийн салбар зөвлөлд ирүүлнэ.
- 2.7 Дотоодын үйлдвэрийн эмийн шошго монгол хэл дээр, импортоор оруулж буй эмийн шошго нь монгол, англи хэл дээр бичигдсэн байна. Эмийн хэрэглэх заавар монгол хэл дээр бичигдэн дагалдана

**Гурав Эмийн бүртгэлийн хугацааг сунгах, бүртгэлээс хасах, хүчингүй болгох**

- 3.1 Эмийн бүртгэлийн хугацааг сунгах
  - 3.1.1 бүртгэлийг анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгана.
  - 3.1.2 бүртгэлийн хугацаа, нөхцөл, шаардлагын зөрчил илрээгүй тохиолдолд лабораторийн дүгнэлтийг үндэслэн, хуралдаанд оруулахгүйгээр шууд сунгана
  - 3.1.2 эмийн бүртгэлийн хугацааг сунгасан тохиолдолд уг эмийн бүртгэлийн дугаар кодыг давтан хэрэглэнэ.
- 3.2. Дараах тохиолдолд эмийг улсын бүртгэлээс, хасах эсвэл хүчингүйд тооцно:
  - 3.2.2 хэрэв бүртгүүлэгч тал эмийн бүртгэлийн хугацаа дуусахаас 3 –аас доошгүй сарын өмнө сунгуулах хүсэлтээ албан ёсоор ирүүлээгүй бол;
  - 3.2.3 хэрэглэх явцад стандартын шаардлагад нийцээгүй буюу гаж нөлөө илэрсэн, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлсөн, өвчний үүсгэгч тухайн эмэнд дасал болсон нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
  - 3.2.4 тухайн үйлдвэрлэгч эмийг хуурамчаар үйлдвэрлэсэн, дууриамлаар савласан болох нь нотлогдсон;
  - 3.2.5 бичиг баримт нь хуурамчаар үйлдэгдсэн болох нь нотлогдсон;
- 3.3. Тухайн эмийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг Эмийн зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 14 хоногт багтаан бүртгүүлэгчид албан бичгээр хүргүүлнэ;

#### **Дөрөв. Эмийг шинэчлэн бүртгэх**

- 4.1 Дараах тохиолдолд эмийн улсын бүртгэлийг шинэчилнэ:
  - 4.1.1 тухайн эмийн үйлдвэрийн өмчлөлийн хэлбэр, харьяалал, нэр, хаяг, гарал үүсэл өөрчлөгдсөн;
  - 4.1.2 эмийн үйлдвэрийн технологи, эмийн стандарт, хэрэглэх заавар, тун өөрчлөгдсөн;

#### **Тав. Эмийн бүртгэлийг хөтлөх, гэрчилгээжүүлэлт**

- 5.1 Эмийн бүртгэлийн асуудлыг 2.3, 2.4-д заасан шаардлагыг хангасан материалыг өргөдөл хүлээж авснаас хойш 3 сарын дотор шийдвэрлэнэ.
- 5.2 Эмийг бүртгэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор бүртгэлийн гэрчилгээг олгож, эмийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын гарын үсгээр баталгаажуулна.
- 5.3 Бүртгэлийн гэрчилгээний эх хувийг хуулбарлан авч баталгаажуулан албан хэрэгцээнд ашиглана.
- 5.4 Эмийн улсын бүртгэлийн эмийн гэрчилгээг 5 жил, түүхий эдийн гэрчилгээг 2 жилийн хугацаагаар нэг хувь бичиж үндсэн бүртгүүлэгчид олгох ба мөн түүнтэй адил хугацаагаар сунгана.
- 5.5 Эм, эмийн түүхий эдийн бүртгэлийн хуудас бүрийг баталгаажуулсан тусгай нууцлалтай дэвтэрт холбогдох үзүүлэлтүүдийн дагуу хөтлөнө. Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эд бүрт хавтаст хэрэг хөтлөн, материалыг улам баяжуулан ашиглана.
- 5.6 Бүртгэгдсэн эмийг жилд хоёроос доошгүй удаа вэбсайт, хэвлэлээр нийтэд мэдээлж байна.

#### **Зургаа. Үйл ажиллагааны зардал ба санхүүжилт**

- 6.1 Улсын бүртгэлд эм бүртгэхтэй холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүр төлөвлөж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.
- 6.2 Мал эмнэлгийн эмийн улсын бүртгэлд эм бүртгүүлэхтэй холбогдон гарсан эм бүртгэлийн төлбөр, ажил үйлчилгээний зардлыг бүртгүүлэгч тал хариуцна. Эмийн зөвлөл зардлын хэмжээг тогтооно.

Долоо. Улсын бүртгэлд эм бүртгүүлэх өргөдлийн загвар

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД  
TO MINISTRY OF FOOD, AGRICULTURE AND LIGHT INDUSTRY OF MONGOLIA  
МИНИСТЕРСТВУ ПРОДОВОЛЬСТВИЯ И СЕЛЬСКОГО ХОЯЙСТВА МОНГОЛИИ  
ЭМ, ЭМИЙН БЭЛДМЭЛИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ  
APPLICATION FOR DRUG AND VOIPREPRATION REGISTRATION  
ЗАЯВЛЕНИЕ РЕГИСТРАЦИЙ ЛЕКАРСТВ И БИОПРЕПРАТОВ  
ДЛЯ ГОСРЕГИСТРАЦИЙ

Огноо : он: сар: өдөр:  
Date : Year month day:  
Дата Год Месяц День

1. Анкет  
Application information  
Анкет заявления

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр .....  
Name of film  
Названия предприятия или хозяйственных единиц

Хаяг  
Address  
Адресс

Утас Телекс Факс И-мейл  
Phone Telex Fax E-MAIL

2. Эмийн үйлдвэрлэгчийн нэр .....  
Name of manufacturer  
Название фирмы / производителя

Хаяг .....  
Address  
Адресс

Утас Телекс Факс И-мейл  
Phone Telex Fax E-MAIL

3. Байгууллага он сар  
Established date / Licensed year month  
Дата создания фирмы год месяц

## Найм. Эмийн талаарх мэдээллийн загвар

### ЭМИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### PRODUCT INFORMATION

### ИНФОРМАЦИЯ О ПРОДУКТАХ, ПРЕДСТАВЛЕННЫХ ДЛЯ РЕГИСТРАЦИЙ

1. Эмийн нэр / худалдааны -----  
Trade name of drug or bio preparation

Торговое название препарата

2. Эмийн нэр / Олон улсын -----  
Generic name / INN

Международное название

Международное название

3. Үндсэн үйлчлэгч бодисын нэр -----  
Name of active ingredients

Name of active ingredients

Название действующего вещества

4. Эмийн хэлбэр / хэлбэр тус бүрд өргөдөл бичнэ /-----  
Type of formulation / please complete separate application for each different type /

Type of formulation / please complete separate application for each different type /

Лекарственные формы / для каждой формы продукта /

5. Фармакологийн ангилал

Pharmacological classification

Anatomic therapeutic code / ATC code /

Фармакологическая классификация / АТТК/ АТТ коде /

6. Эмчилгээний тун -----  
Therapeutics dose

Therapeutics dose

Терапевтическая доза

7. Эмийн хэрэглэх заалт -----  
Indication /s/

Indication /s/

Назначение / основное/

8. Мэдээлэгдсэн гаж нөлөө / илэрсэн гаж нөлөөны нэр, тоо /-----  
-----

Reported side effects / name and number of the side effect /

Побочные действия / основные признаки и частота /

9. Савлагааны хэлбэр /бөөнөөр савласан, жижиглэн савласан, овор хэмжээ /

Packaging forms / bulk, unit dose, sizes /-----

Форма упаковок

10. Хаяглалт -----  
Labeling

Labeling

Этикетка

11. Эмийн найрлагад байгаа туслах бодисын нэр -----  
Name of inactive ingredients

Name of inactive ingredients

Название вспомогательных веществ, входящих в состав формы

12. Эмийн хүчинтэй хугацаа -----  
Shelf life

Shelf life

Срок хранения

13. Хадгалах, тээвэрлэх нөхцөл -----  
Distribution and storage conditions  
Условия хранения и транспортировки

14. Уг эм анх хэдэн онд бүртгэгдсэн -----  
Number of the registered officially  
В каком году было зарегистрировано впервые

15. Одоо хэдэн оронд бүртгэдээд байгаа -----  
Number of the registered country  
В скольких странах зарегистрировано в настоящее время

Documents ;

**Sinnature of the applicant**

**Address:**

**Council of Drugs & Biopreparations  
Ministry Food, Agriculture and Light Industry of Mongolia  
Enkh taivan Street  
Ulaanbaatar  
Mongolia.**

**Ес. “Малын эмийн улсын бүртгэлд мал эмнэлгийн  
эмийн түүхий эд бүртгүүлэх өргөдөл”-ийн маягт**

**УЛСЫН БҮРТГЭЛД МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД  
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ  
ACTIVE VETERINARY DRUG INGREDIENT REGISTRATION  
APPLICATION FORM**

1. Эмийн түүхий эд / Active pharmaceutical ingredients (API)

Өргөдлийн хэлбэр ( холбогдох бөөрөнхийг тэмдэглэнэ үү.)  
Type of application ( Please tick as appropriate.)

- Шинээр бүртгүүлэх эмийн түүхий эд  
New registration for a active pharmaceutical ingredient
- Тухайн бүртгүүлсэн түүхий эдэд тойм үзлэг хийх  
Periodic review of an existing marketing authorization

Өргөдлийг Монгол, Англи эсхүл Орос хэл дээр бөглөнө.  
(Fill in the application in Mongolian, English or Russian)

<b>I хэсэг Part I</b>	<b>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> Өргөдөл гаргач нь GMP-ийн шаардлага хангасан эм үйлдвэрлэгч эсхүл гадаадын үйлдвэрийг Монголд төлөөлөх эрхтэй аж ахуйн нэгж байна.  APPLICANT INFORMATION The applicant should be a drug manufacturer that fulfills GMP requirements or business entity authorized to represent a foreign manufacturer
<b>Нэр</b> Name	
<b>Ажлын хаяг</b> Business address	
<b>Шуудангийн хаяг</b> Postal address	
<b>Утас, факсын дугаар</b> Telephone & fax number	
<b>Е-мейл хаяг</b> E-mail address	
<b>Харилцах албан тушаалтан</b> Contact person	
<b>II Хэсэг Part II</b>	<b>Үйлдвэрлэгчийн талаарх мэдээлэл Manufacturer information</b>
<b>Эмийн үйлдвэрлэгчийн нэр</b> Name of manufacturer	
<b>Шуудангийн хаяг</b> Postal address	
<b>Утас, факсын дугаар</b> Telephone & fax number	
<b>Е-мейл хаяг</b> E-mail address	

<b>Байгуулагдсан он ;</b> Established date / Licenced	
<b>III Хэсэг</b> <b>Part III</b>	<b>Бүтээгдэхүүний талаарх мэдээлэл</b> <b>Product information</b>
<b>Үйлчлэгч бодисын нэр</b> Name of pharmaceutical active ingredient	
<b>Эмийн түүхий эдийн байгаль дээрх изомерууд</b> If relevant, the isomeric nature ingredient	
<b>Эмийн түүхий эдийн уусалт</b> The solubility of the API	
<b>Хадгалах нөхцөл</b> Storage condition	
<b>Хүчинтэй хугацаа</b> Shelf life	
<b>Савлагааны хэлбэр :</b> Packaging forms	
<b>Гадаад байдал</b> Description	
<b>Улсын нэр</b> Country of origin	
<b>Үйлдвэрлэгч улсын бүртгэлийн дугаар</b> Registration number in country of origin	
<b>Бүртгэгдсэн он сар өдөр</b> Date of registration	
<b>Эмийн түүхий эдийн бүртгэлд шаардлагатай материалууд</b> / Required materials for API registration /	
<b>1. Өргөдөл гаргачийн талаарх мэдээлэл</b> /applicant information /	
<p><b>1.1 Аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний баталгаатай хувь</b> / Notarized copy of the certificate of Company/ Business registration /</p>	
<p><b>1.2 Үйлдвэрлэл явуулж буй байрны зөвшөөрөл</b> / Factor premises by the district office /</p>	

**ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**  
Manufacturer information

1. **Үйлдвэрийн танилцуулга**  
Profile of the manufacturer

**GMP**

2. **Холбогдох эрх бүхий хяналтын байгууллагаас үйлдвэрлэгч нь GMP –ийн шаардлага хангасан болохыг нотолсон баримт бичиг**  
/ document from relevant drug control authority certifying that the manufacturer is in compliance of the GMP requirements of the country /

**Бүтээгдэхүүний талаарх мэдээлэл**  
Product information

1. **Бүтээгдэхүүний тодорхойлолт / физик үзүүлэлт /**  
Product specifications

**Эм зүйн үзүүлэлтүүд**

3. **Цувралын сертификат**  
Batch certificate

4. **Шинжилгээний аргачлал**  
Method of analysis of the API

5. **Лабораторийн бүрэн шинжилгээнд хүрэлцэхүйц хэмжээний эмийн түүхий эдийн болон стандарт бодисын дээж чанарын сертификатын хамт**  
Samples of the API, and reference substances with certificate of analysis (adequate quantity for laboratory testing)

..... ( нэр) Монгол улсын Малын эмийн бүртгэлд бүртгүүлэхээр авч ирсэн бүх баримт бичиг, өргөдөл нь үнэн бөгөөд эх хувь байна.

..... гарын үсэг ..... он ..... сар ..... өдөр

I ..... declare that the particulars given in this application are true and correct, and that all accompanying reports and documents supplied for the registration of active pharmaceutical ingredients in Mongolia are true and are authentic copies.

Date ..... Authorized signature .....

Арав. “Малын эмийн улсын бүртгэлд эх орны эмийг бүртгүүлэх өргөдөл”-ийн маягт

**УЛСЫН БҮРТГЭЛД ЭХ ОРНЫ ЭМИЙГ  
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

**DRUG REGISTRATION APPLICATION FORM**

Эх орны эм

Өргөдлийн хэлбэр

Шинээр бүртгүүлэх

Бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгүүлэх

<b>I ХЭСЭГ</b>	<b>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> Өргөдөл гаргагч нь стандартын шаардлага хангасан эмийн үйлдвэр байна.		
Нэр			
Ажлын хаяг			
Шуудангийн хаяг			
Утас, факсын дугаар			
Е-мейл хаяг			
Харилцах албан тушаалтан			
<b>II ХЭСЭГ.</b>	<b>БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>		
Эмийн худалдааны нэршил			
Эмийн ерөнхий нэршил (Хэрвээ байгаа бол олон улсын нэршил )			
<b>Үйлчлэгч бодисын нэр, тун хэмжээ</b>			
Нэр	тун хэмжээ	Нэр	тун хэмжээ
1		5	
2		6	
3		7	
4		8	

<b>Туслах бодисын нэр, тун хэмжээ</b>			
Нэр	тун хэмжээ	Нэр	тун хэмжээ
1		6	
2		7	
3		8	
4		9	
5		10	
Эмийн хэлбэр			
Хадгалах нөхцөл			
Хүчинтэй хугацаа			
Савлагааны хэлбэр			
Савлагааны хэмжээ			
Олгох нөхцөл			
Хэрэглэх арга, зам			
Фармакологийн ангилал			
Гадаад байдал	өнгө/	Хэлбэр/	хэмжээ
	Бусад		
Хэрэглэх заалт			
Хориглох заалт			
Гаж нөлөөний талаарх мэдээлэл			

<b>Эх орны эмийн бүртгэлд шаардлагатай материалууд</b>	
<b>6. Өргөдөл гаргачийн талаарх мэдээлэл</b>	
a. 5.1 Аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний баталгаатай хувь	
b. 5.2 Эмийн үйлдвэрлэл явуулах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	
c. 5.3 Үйлдвэрлэлийн танилцуулга	

## 7. Бүтээгдэхүүний талаарх мэдээлэл

(Физик үзүүлэлтүүд)

a. 6.1 Бүтээгдэхүүний тодорхойлолт

b. 6.2 Бүтээгдэхүүний хадгалах хугацааг баталсан тогтвортой чанарын үзүүлэлт

(Эм зүйн үзүүлэлтүүд)

c. 6.3 Монгол Улсын стандарт, батлагдсан хэрэглэх заавар

d. 6.4 Батлагдсан технологийн заавар

e. 6.5 Үйлдвэрлэлийн процесс, схем (Дамжлага дундын хяналтыг оруулах)

f. 6.6 Бусад эмтэй харилцан нөлөөлөх нөлөөлөл

Эмнэл зүйн үзүүлэлт

g. 6.7 Эмийн хоруу чанар, идэвх, аюулгүй байдлыг судалсан судалгааны товч дүгнэлт

Эмийн дээж

h. 6.8 Лабораторийн бүрэн шинжилгээнд хүрэлцэхүйц хэмжээний эмийн болон стандарт бодисын дээж, чанарын сертификатын хамт

i. 6.9 Эмийн хаяглалт, дагалдах мэдээлэл, эмийн хайрцаг (эмийн цуврал, хүчинтэй хугацаа, ямар нэг сануулгыг оруулах)

Жич: Дээрх маягтад бичигдсэн заалтуудыг бөглөхдөө тухайн заалтын дагуух дөрвөлжинг “✓” тэмдэгээр тэмдэглэх бөгөөд уг заалтыг баримт бичиг, холбогдох материалаар нотолж өргөдөлд хавсаргасан байна.

..... ( нэр ) Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн бүх баримт бичиг, өргөдөл нь үнэн бөгөөд эх хувь байна.

..... гарын үсэг, .....он ..... сар .....өдөр

## Арван нэг. Хариуцлага

- 11.1 Энэ дүрмийг зөрчсөн иргэн хуулийн этгээдэд “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” болон “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”, болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ

-----oO-----

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2009 оны 11 дүгээр сарын 19 ний өдрийн  
261 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ  
ЭМ БОЛОН ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

д/ д	Эмийн нэр /Олон улсын нэршил/	Эмийн хэлбэр, савлалт	Олгох нөхцөл /Ж,ЖГ, ТХ/	Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний нэгжийн шаталбар	
				Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн алба	Сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
	01	02	03	04	05

**1. Ерөнхий мэдээгүйжүүлэх эм**

1	Изофлуране /Isoflurane/	Амьсгалаар хэрэглэх	Ж	+	+
2	Кетамин гидрохлорид /Ketamine hydrochloride/	Амьсгалаар хэрэглэх, тарилгын уусмал, 5 %, 2-10 мл, тун шилтэй	ТХ	+	+
3	Тиопентал натри /Tiopental natrii/	Тарилгын нунтаг, 0.5 гр, 1 гр тун шилтэй	Ж	+	+
4	Барбитал /Barbital/	Тарилгын нунтаг, шахмал 0,5 гр	Ж	+	+
5.	Эфир /наркозын/ зориулалттай	Шингэн, 0,1 литр, шилэнд	Ж	+	+
6	Промайсе /Promaise/	Шингэн, 50 мл, лонхонд	Ж	+	+
7	Робинал-В /Robinal –В/	Шингэн, 20 мл, лонхонд	Ж	+	+

**2. Хэсэг газрыг мэдээгүйжүүлэх, тайвшруулах эм**

1	Прокайн /Procaine/	Нунтаг, Тарилгын уусмал, 0.25%, 0.5%, 1 %, тун шил, флаконтой	ЖГ	+	+
